

МББСБХолбооны гишүүний ёс зүйн дүрэм

Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1 МББСБХолбооны гишүүн ББСБ нь Холбооны дүрэмд заасан эрхээ эдлэж, үүргээ хүлээн холбооны өмнөө тавьсан зорилго, зорилтыг хэрэгжүүлэх, холбооноос олгосон эрхийн дагуу бусад төрийн болон төрийн бус байгууллагад төлөөлөх, дүрэмд заагдсан үндсэн чиглэлийн дагуу хийж гүйцэтгэж буй ажил, арга хэмжээнд оролцохдоо баримтлах зарчим, ёс зүйн хэм хэмжээг тогтоож мөрдүүлэх, хэм хэмжээг зөрчсөн гишүүнд хариуцлага хүлээлгэх, шийдвэрлэхэд энэхүү дүрмийн зорилго оршино.
- 1.2 Энэхүү дүрмийн хэрэгжилтэнд Холбооны удирдах зөвлөлийн гишүүд хяналт тавих бөгөөд хэм хэмжээг зөрчсөн гишүүнд удирдах зөвлөлийн хурлын шийдвэрээр хариуцлага хүлээлгэнэ.
- 1.3 ББСБ нь санхүүгийн үйлчилгээг бизнесийн өндөр ёс зүйтэй, зарчимч, хууль, журмыг сахин биелүүлж ажиллах нь нийт гишүүдийн үүрэг болно.

Хоёр. МББСБХолбооны гишүүний баримтлах зарчим, ёс зүйн хэм хэмжээ.

- 2.1 Холбооны дүрэм, журам, шийдвэрийг чанд сахин биелүүлэх,
- 2.2 Монгол улсын Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хууль, СЗХ-ноос гаргасан дүрэм журам, тогтоол, шийдвэрийг чанд сахин биелүүлэх,
- 2.3 Холбооны гишүүдийн нийтлэг ашиг сонирхлыг өөрийн байгууллагын ашиг сонирхлоос дээгүүр тавих,
- 2.4 Гишүүн нь холбооны гишүүн болон гишүүн бус ББСБ-уудын төлөөлөлтэй ажил хэрэгч, соёлч боловсон, хүндэтгэлтэй харилцах
- 2.5 Холбооны удирдлагаас өгсөн үүрэг даалгаврыг биелүүлэх, үйл ажиллагаанд идэвхтэй, ажил хэрэгч, санаачлагатай, хариуцлагатай оролцох
- 2.6 ББСБ-ын салбар, Холбооны нэр хүндийг өндөрт өргөж ажиллах
- 2.7 Холбооноос өгөгдсөн эрх мэдлийн хүрээнд нийтэд мэдээлэл, мэдэгдэл хийх
- 2.8 Салбарын нэр хүндэд болон гишүүдийн үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлөхүйц үйлдэл, эс үйлдэл хийхгүй байх
- 2.9 Холбооны талаар үндэслэлгүй ташаа мэдээлэл үл өгөх
- 2.10 Хууль бус үйлдэл, эс үйлдэл хийхгүй байх
- 2.11 Холбооны үйл хэрэг, үйл ажиллагаанд саад хийхгүй байх
- 2.12 Холбоог хагалан бутаргах үйл ажиллагаа явуулах, үйл хэргийг сулруулах үйлдэл, эс үйлдэл хийхгүй байх
- 2.13 Холбооны үйл ажиллагааны талаар эсрэг сурталчилгаа хийхгүй байх

2.14 Холбооны үйл ажиллагааг гутаан доромжлохгүй байх

Гурав. Хариуцлага

- 3.1 Холбооны гишүүн нь энэхүү дүрмийн 2.1-2.9 заалтыг зөрчсөн тохиолдолд Холбооны удирдах зөвлөл дараах хариуцлагыг хүлээлгэнэ.
 - 3.1.1 Сануулах
 - 3.1.2 Хатуу анхааруулах
- 3.2 Холбооны гишүүн нь энэхүү дүрмийн 2.10-2.14 заалтыг зөрчсөн тохиолдолд Холбооны удирдах зөвлөл дараах хариуцлагыг хүлээлгэнэ.
 - 3.2.1 Гишүүнээс хасах
 - 3.2.2 Олон нийтэд мэдээлэх
- 3.3 Удирдах зөвлөлийн гишүүн нь энэхүү дүрмийн 2.1-2.9 заалтыг зөрчсөн тохиолдолд Холбооны удирдах зөвлөл дараах хариуцлагыг хүлээлгэнэ.
 - 3.3.1 Сануулах
 - 3.3.2 Хатуу анхааруулах
- 3.4 Энэхүү дүрмийн 2.10-2.14 заалтыг зөрчсөн эсхүл Удирдах зөвлөлийн хурлыг хүндэтгэн үзэх шалтгаангүй 3 удаа дараалан эсхүл нийт 6-н удаа тасалсан бол Холбооны удирдах зөвлөлийн шийдвэрээр Удирдах зөвлөлийн гишүүнээс эргүүлэн татах үндэслэл болно.
- 3.5 Гишүүн ББСБ-ын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг СЗХ-ноос түдгэлзүүлсэн бол 3.2.1, 3.4 заалтын хариуцлага тооцогдох үндэслэл болно.

МОНГОЛЫН БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГУУДЫН ХОЛБОО